

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах” тухай Монгол Улсын Шадар сайд М.Энхболдын илтгэлийн баримт бичигтэй ажлын журмаар танилцаад ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Монгол Улсын Засгийн газарт:

1. Орон нутагт ажиллаж буй газар хөдлөлт бүртгэх станц, боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, үйл ажиллагааг нь олон улсын түвшинд хүргэхэд гадаадын мэргэжлийн тэргүүлэх байгууллагуудтай хамтарч ажиллах, газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох, төв суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлтэй нутаг дэвсгэрт барилгажуулах боломжтой газрыг тодорхойлох арга хэмжээ авах, (Аймаг, нийслэлийн Засаг дарга, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв)

2. Нийслэл, хот орчмын газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд геофизикийн иж бүрэн судалгаа явуулах, хүчтэй газар хөдлөлтийн голомтууд дээр урьдчилан таамаглах геофизикийн ажиглалтын байнгын цэг байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, (Сангийн яам, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв)

3. Газар хөдлөлтийн гамшгийн үед аврах ажиллагаанд шаардагдах техник, тоног төхөөрөмж, ашиглалтын шаардлага хангахгүй барилга, байгууламжуудын шинэчлэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгаж шийдвэрлүүлэх, (Сангийн яам, Онцгой байдлын ерөнхий газар)

4. Газар хөдлөл судлал, барилга байгууламжийн хийц, бүтээцийн сорил шинжилгээний лаборатори, барилгын зураг төсөл, эрдэм шинжилгээ, судалгааны төв байгуулах арга хэмжээг авах, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, нийслэлийн Засаг дарга)

5. Орон сууц, олон нийт, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын барилга байгууламжуудын газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлын үзлэг, шалгалтыг хийх, бүх барилгыг паспортжуулан ашиглалтын хэвийн нөхцөлөөр хангуулж, мэдээллийн сан байгуулах, бүсийн тулгуур төв, аймаг, нийслэлийн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг хийх, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, төлөвлөлтийг боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан хамтарч ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх, (Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар)

6. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга)

7. Гамшгийн үед онцгой горимоор ажиллах шаардлагатай дулааны цахилгаан станц, цахилгаан, дулааны эрчим хүч дамжуулах, түгээх байгууламж, тээвэр, ачаа, зорчигчийн терминал, харилцаа холбоо, телевиз, радио зэрэг дэд бүтцийн объектууд, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, химийн болон бусад хорт бодис, нян өсгөвөр бүхий газруудын аюулгүй ажиллагааны журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга)

8. Газар хөдлөлтийн голомтоос аюулын мэдээллийг хотын хэмжээнд шуурхай мэдээлэх дуут болон бусад дохиоллын систем, “амжиж анхааруулах тогтолцоо”-г байгуулж, сургалтын дохиогоор авран хамгаалах, хор уршгийг арилгах, нүүлгэн шилжүүлэх ажиллагааны сургуулилтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж хэвших, (Сангийн яам, ОБЕГ, нийслэлийн Засаг дарга, Одон орон, геофизикийн судалгааны төв)

9. Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд болзошгүй газар хөдлөлтийн үед авран хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, (Онцгой байдлын ерөнхий газар)

10. Гамшгийн үед шаардагдах нөөц байр сууц, хүнс, дулаан хувцас, хээрийн эмнэлэг, эмнэлгийн тусламж үйлчилгээ, хүн хүч, техник хэрэгсэл, машин механизмын дайчилгааны төлөвлөгөө-хангалтын тооцоог улирал бүр нягтлан тодотгох, хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах агуулах сав, нисэх онгоцны нөөц

